



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/654

Ховд

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 4/03 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 59 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд “COVID-19”-ын цар тахалын гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үеийн мэргэжлийн байгууллагуудын 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны үйл ажиллагааны зардлын эцсийн санхүүжилтэнд 139 343 090 төгрөг /нэг зуун гучин есөн сая гурван зуун дөчин гурван мянга ерөн/-ийг гэснийг тооцооллын алдааг залруулан “149 214 944 төгрөг /нэг зуун дөчин есөн сая хоёр зуун арван дөрвөн мянга есөн зуун дөчин дөрвөн/” гэж өөрчлөлт оруулан зарцуулсугай.

2. Тооцооллын алдааны санхүүжилтийн зөрүү нийт 9 871 854 төгрөг /есөн сая найман зуун далан нэгэн мянга найман зуун тавин дөрвөн/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2021 оны батлагдсан төсвөөс нэмж санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ